



Орхонгог тутмын хэвлэл
№ 08 дугаар сарын 18
№31 /700/

ТТШЛААЕ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Иргэдийн газрын
тогтоол


357

Монгол Улсын
Иргэдийн газрын
тогтоол

360

**Мал аж ахуйн салбарын
2011-2012 оны өвөлжилтийн
бэлтгэл хангах зарим арга
хэмжээний тухай**

Аргачлал батлах тухай



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

334.	Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 192	1357
335.	Аргачлал батлах тухай	Дугаар 193	1360
336.	Үндэсний хорооны ажлын алба байгуулах тухай	Дугаар 209	1366
337.	Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай	Дугаар 210	1367

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 6 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар
хот

Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдох үед хэрэглэх аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх доод хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:

2.1. Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг малчид, мал бүхий иргэдийн хүчийг нэгтгэж төлөвлөгөө гарган зохион байгуулах, нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлага, ажилтнуудыг хуваарийн дагуу ажиллуулан



биелэлтийн явцыг дүгнэж байх.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, явцад нь хяналт тавьж ажиллах.

2.3. Мал сүргийн зун, намрын отрыг сайтар зохион байгуулж, тарга хүч авахуулах.

2.4. Улсын хэмжээнд хээлтүүлэгч малын хүрэлцээ хангалтгүй байгааг харгалзан хээлтүүлэгч нөхөн тавих, худалдан авах ажлыг зохион байгуулан өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн болон эрлийз малд зохиомол хээлтүүлэг хийх арга хэмжээ авах.

2.5. Мал сүргийг халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулгалтад бүрэн хамруулах ажлыг 2011 онд багтаан гурван удаа нэгдсэн байдлаар зохион байгуулах.

2.6. Мал өвөлжүүлж, хаваржуулах хашаа, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор тэдгээрийг засварлах, шинээр хашаа барих, худаг гаргах ажлыг зохион байгуулах.

2.7. Төв, суурин газрын хүн амыг мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах арга хэмжээ авч, 2012 оны хавар хэрэглэх махны нөөц бүрдүүлэх арга хэмжээ авах.

3. Зуны агаарын хэт халалт, хуурайшилт, ган, үерийн улмаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, гамшигт үзэгдэл тохиолдсон үед шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимтэй зохион байгуулж, явцыг нь сар бүр хянан шалгаж, 2011-2012 оны өвөл, хавар отор нүүдлээр өвөлжүүлэх малын тоо, оторлох бэлчээр нутгийг сонгон аймаг, сумын удирдлагын түвшинд хэлэлцээ хийх, отрын нутагт хүрэх нүүдлийн замыг тогтоох зэрэг арга хэмжээг энэ оны 9 дүгээр сард авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ, түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар

тэжээлээ өрхөөрөө болон хамтарч хоршин нөөцлөх, өвлийн хувцас хэрэгсэл, мал аж ахуйн тоног хэрэгслээ засварлах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангахыг малчин өрх, мал бүхий иргэдэд уриалсугай.

6. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, мал өвөлжилтийн бэлтгэлийг ханган, дүнг 2011 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2011 оны 192 дугаар
тогтоолын хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН
АЮУЛГҮЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ДООД ХЭМЖЭЭ**

№	Аймгийн нэр	Аймаг, нийслэл		Сум, дүүрэг	
		Өвс (тн)	Тэжээл (тн)	Өвс (тн)	Тэжээл (тн)
1	Архангай	1000	200	100	50
2	Баян-Өлгий	800	200	100	50
3	Баянхонгор	400	200	50	50
4	Булган	1200	300	100	50
5	Говь-Алтай	400	200	50	50
6	Говьсүмбэр	200	100	50	50
7	Дархан-Уул	800	200	100	50
8	Дундговь	500	200	50	50
9	Дорноговь	300	100	50	50
10	Дорнод	1000	200	100	50
11	Завхан	1200	200	100	50
12	Орхон	500	150	100	70
13	Өвөрхангай	1200	300	100	70



14	Өмнөговь	300	100	50	50
15	Сэлэнгэ	1200	400	100	80
16	Сүхбаатар	800	200	100	50
17	Төв	1200	300	100	50
18	Увс	1000	400	80	40
19	Ховд	1000	300	80	40
20	Хөвсгөл	1200	300	100	50
21	Хэнтий	1000	300	100	50
22	Улаанбаатар	400	200	50	50
	Дүн	17600	5050		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 6 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Аргачлал батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 47.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал”-ыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

Засгийн газрын 2011 оны 193 дугаар
тогтоолын хавсралт

**АШИГТ МАЛТМАЛЫН ХҮДЭР, БАЯЖМАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
АНГИЛАЛ, ТООЦОХ ҮНДСЭН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан

болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтооход ашигт малтмалын хүдэр, баяжмал, эцсийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах үндсэн шаардлага, тооцох зарчмыг тодорхойлоход энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Ашигт малтмалын хүдэр, баяжмал, боловсруулсан эцсийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах үндсэн шаардлага, түүнийг тооцох зарчмыг тодорхойлохдоо Гаалийн төв лабораторийн шинжилгээний дүнг үндэслэнэ. Гаалийн байгууллага нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх дүгнэлт гаргах эрх бүхий бусад итгэмжлэгдсэн лабораториор тухайн бүтээгдэхүүний чанар, агуулга, найрлагын талаархи шинжилгээ хийлгэж болно.

Хоёр. Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал

2.1. “Ашигт малтмалын хүдэр” гэж газрын гадаргуу, түүний хэвлийд геологийн хувьсал, өөрчлөлт, физик-химийн процессын үр дүнд үүсэж бий болсон бөгөөд түүнд агуулагдаж байгаа ашигт элементийг (металл) нь олборлож, боловсруулж, ялгахад эдийн засгийн ач холбогдол бүхий уулын чулуулгийг хэлнэ (боловсруулаагүй нүүрс энэ ангилалд орно).

2.2. Ашигт малтмалын хүдэрт тавигдах шаардлага, түүнийг тооцох үндсэн зарчмыг дараахь байдлаар тодорхойлно:

№	Бүтээгдэхүүний нэр	Шаардлага	Тооцох зарчим	
1	Зэсийн хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤20%
2	Цайрын хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤35%
3	Молибденийн хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤45%
4	Төмрийн хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон уулын чулуулаг болон хуурай соронзон аргаар баяжуулсан чулуулгийг оруулна	агуулга	≤70%



5	Гянтболдын хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤20%
6	Хайлуур жоншны хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон уулын чулуулаг болон металлургийн баяжмалыг оруулна	агуулга	Хүдэр: ≤55%
				Баяжмал: >55%
7	Цагаан тугалганы хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤5%
8	Хар тугалганы хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤35.45%
9	Боловсруулаагүй нүүрс	Газрын хэвлийгээс олборлосон болон бохирдлыг бууруулсан, ширхэглэлт, жигдрүүлэлт хийсэн нүүрсийг оруулна		
10	Магнезитын хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤39%
11	Хөнгөн цагааны хүдэр-боксит	Газрын хэвлийгээс олборлосон уулын чулуулаг болон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна. Хөнгөн цагааны хүдэр-боксит нь хөнгөн цагааны исэл, пулсагийн гидрат, төмрийн исэл ба кремни зэргээс бүрдэнэ	Боксит дахь пулсагийн агуулга 40-60% болон түүнээс дээш байна	
12	Газрын ховор элементийн хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна		Газрын хөрсөн дэх лантанаидын бүлгийн элементүүдийн дундаж нийлбэр агуулга нь ойролцоогоор 0.001% байна
13	Фосфоритын хүдэр	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤28%
14	Цесльтын хүдэр	Цеолидын хүдэр нь байгаль дээр 100 гаруй төрөл байх бөгөөд хүдэр нь цеолидын агуулгаас хамаарч баян, ядуу гэж ангилагддаг	агуулга	≤6.5%

15	Судлын кварц	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй уулын чулуулгийг оруулна	агуулга	≤95%
16	Чулуун давс	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй бохир давсыг оруулна		
17	Мөсөн шүү	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй мөсөн шүүг оруулна		
18	Гөлтгөнө	Газрын хэвлийгээс олборлосон боловсруулалт хийгдээгүй гөлтгөнийг оруулна		

2.3. “Ашигт малтмалын баяжмал” гэж хүдрийг боловсруулах явцад гаргаж авсан ашигт эрдсийн агуулга нь өндөрссөн бүтээгдэхүүнийг хэлнэ.

2.4. Ашигт малтмалын баяжмалд дараахь бүтээгдэхүүнийг оруулна:

№	Бүтээгдэхүүний нэр	Шаардлага	Тооцох зарчим	
			агуулга	
1	Зэсийн баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>20%
			ширхэглэл	<0.074 мм: 80%
			чийглэг	<14%
2	Цайрын баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>35%
			ширхэглэл	<0.1 мм: 100%
				<0.074 мм: 95%
чийглэг	<12%			
			өвөл: <8%	
3	Молибденийн баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>45%
4	Төмрийн баяжмал	Хуурай соронзон аргаар баяжуулснаас бусад аргаар баяжуулсан баяжмалыг оруулна	агуулга	>58%
			ширхэглэл	0.044 мм: 60-98%
			чийглэг	<11.5%
5	Гянтболдын баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>20%



6	Хайлуур жоншны баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн флотацын баяжмалыг оруулна	ФФ-95	>95%
			ФФ-97	>97%
7	Цагаан тугалганы баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>5%
8	Хар тугалганы баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>35.45%
			ширхэглэл	<0.1 мм: 100%
				<0.074 мм: 95%
чийглэг	<12%			
				өвөл: <8%
9	Баяжуулсан нүүрс	Хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн нүүрсийг оруулна		
10	Магnezитийн баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>39%
11	Хөнгөн цагааны баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	агуулга	>45%
12	Газрын ховор элементийн баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн баяжмалыг оруулна	Газрын ховор элемент агуулсан хүдрийг баяжуулан гаргаж авсан болон химийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүн. Бүтээгдэхүүн дэх газрын ховор элементүүд, тэдгээрийн ислийн нийлбэр агуулга нь хүдрийн гарал үүсэл, эрдсүүдийн шинж чанар, агуулгаас хамааран 60 хувиас багагүй байх	
13	Фосфоритын б.я.к.г.г.л	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн фосфобаяжмалыг оруулна.	агуулга	>28%
			ширхэглэл	>0.16 мм: <20%

14	Цеолитын баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн цеолитыг оруулна	агуулга	>66.5%
15	Судлын кварц	Баяжуулах аргаар боловсруулж хүдэр дэх агуулгыг нь дээшлүүлсэн кварцыг оруулна	агуулга	>95%
16	Чулуун давсны баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж ууталж савласан чулуун давсыг оруулна		
17	Мөсөн шүүний баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж агуулгыг нь дээшлүүлэн ууталж савласан шүүг оруулна		
18	Гөлтгөнийн баяжмал	Баяжуулах аргаар боловсруулж агуулгыг нь дээшлүүлсэн гөлтгөнийг оруулна		

2.4. “Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүн” гэж баяжмалыг боловсруулж цэвэршүүлсэн металл (нүүрсний эцсийн бүтээгдэхүүн)-ыг хэлнэ.

2.5. Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнийг дараахь байдлаар тодорхойлно:

№	Бүтээгдэхүүний нэр	Шаардлага	Тооцох зарчим	
1	Зэс	Катодын зэс	агуулга	≥99.99
		Хар зэс	агуулга	≥99.00
2	Алт	Хайлуулж цэвэршүүлсэн алт	сорьц	≥99.99
		Хайлуулж цэвэршүүлээгүй алт	сорьц	<99.99
3	Цайр	Хольцгүй цэвэр цайр	агуулга	≥99.99
4	Молибдени	Молибденийн баяжмалыг боловсруулах замаар гарган авсан молибденийн исэл болон цэвэршүүлсэн молибдени		
5	Төмөр	Төмрийн баяжмалаас гаргаж авсан ангижруулсан болон хорголжин буюу тэдгээртэй адил төст хэлбэртэй тайрдас төмөрлөг бүтээгдэхүүн		



6	Цагаан тугалга	Хольцгүй цагаан тугалга	агуулга	≥99.99
7	Хар тугалга	Хольцгүй хар тугалга	агуулга	≥99.99
8	Нүүрсний эцсийн бүтээгдэхүүн	Хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн		
9	Мөнгө	Хайлуулж цэвэршүүлсэн мөнгө	сорьц	≥99.99
		Хайлуулж цэвэршүүлээгүй мөнгө	сорьц	<99.99
10	Хөнгөн цагаан	Хольцгүй хөнгөн цагаан	агуулга	≥99.99
11	Фосфорит	Фосфорын хүчил, дан суперфосфат (МАФ), диаммонифосфат (ДАФ)	агуулга (ДАФ)	≥60.0
			агуулга (МАФ)	≥30.0

Гурав. Хяналт тавих

3.1. Энэхүү аргачлалын хэрэгжилтэд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хяналт тавьж ажиллана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Үндэсний хорооны ажлын алба байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Иргэний нийгмийн байгууллагууд, Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны хооронд байгуулсан "Хамтын ажиллагааны гурван талт гэрээ"-ний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих, төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах, нэгдсэн бодлогоор хангах чиг үүрэг бүхий Үндэсний Хорооны ажлын алба (Төв)-ыг байгуулсугай.

2. Улсын төсвөөс санхүүжих ажлын албаны орон тооны хязгаарыг 5 хүртэл байхаар тогтоосугай.

3. Ажлын албаны 2011 оны үйл ажиллагааны зардал болох 44, 543.100 (дөрвөн дөрвөн сая таван суун дөчин зургаан мянга нэг зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргаж, цаашид тус ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын сайд, Засгийн



газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар
хот

Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 90 жилийн ойг тохиолдуулан дараахь хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

- | | |
|----------------------------------|--|
| 1.Дэмбэрэлсүрэнгийн
Түвшинтөр | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
Хуулийн хэлтсийн дарга |
| 2.Түдэвхүүгийн Гантулга | -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
ямны Төрийн нарийн бичгийн дарга |
| 3.Батсүхийн Бямбажав | -Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын
ямны Төрийн захиргааны удирдлагын
газрын дарга |
| 4.Бямбажавын Ганбат | -Сангийн яамны Хууль эрх зүйн газрын
дарга |
| 5.Шаравын Мөнхцэрэн | -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
дарга |
| 6.Чойжинжавын
Цогтбаатар | -Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул
уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын
орлогч дарга |
| 7.Намнангийн Нямжав | -Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Элчин
сайдын яамны элчин зөвлөх |



- | | |
|---------------------------------|---|
| 8.Бужийновын
Амгаланбаатар | -Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга |
| 9.Даваажавын
Өнөржаргал | -Нийслэлийн клиникийн I амаржих газрын эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч |
| 10.Гомбосүрэнгийн
Бадамдулам | -Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн |
| 11.Шаравын Мэндсайхан | -Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын ахлах мэргэжилтэн |
| 12.Дашаагийн Цэдэнбал | -Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн |
| 13.Лхаахүүгийн Гэрэлмаа | -Оюуны өмчийн газрын шинжээч |
| 14.Аюушжавын Ханддорж | -Булган аймгийн Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн багш |
| 15.Доржпүрэвийн
Бадамцэцэг | -Төв аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн дарга |
| 16.Мөнхбатын
Даваажаргал | -Сумо бөхийн их аварга |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Ханг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн зуудас 9.75

Индекс: 14003

